



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/133

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулж буй “Бидний бахархалт бизнес гэр бүл” арга хэмжээний хүрээнд бизнесийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж буй бизнес эрхлэгч Б.Долгорсүрэн, Б.Оюунцэцэг, Т.Батжаргал нарыг Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнахад 90000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 90000 төгрөг /Ерэн мянга/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
03 дугаар сарын 05-ны өдрийн
А/133 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Б.Долгорсүрэн	Хан-Орд хүнсний зах бизнес эрхлэгч	30000
2	Б.Оюунцэцэг	Бугаан гол зах бизнес эрхлэгч	30000
3	Т.Батжаргал	Баруун бүсийн төв зах бизнес эрхлэгч	30000
Дүн			90000

-оОо-